

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын даргын
2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1102
дугаар тушаалын 16 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

☐ Нийслэлийн Засаг даргын захирамж, Газрын захирлын тушаалаар байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомжийн огноо: Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/156 дугаар захирамж

Дагаж мөрдөх огноо: 2023.04.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2023.03.31

1. Байгууллагын нэр	2. Нэгжийн нэр
“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-азар	Маркетинг хамтын ажиллагааны алба
Албан тушаалын нэр: Хуулийн зөвлөх	Албан тушаалын ангилал Зэрэглэл: ТҮ-8
Ажлын цаг: 8/40 цаг	Ажлын байрны албан ёсны байршил: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Хан-Уул товер 1004 тоот
Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн	Онцгой нөхцөл: Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

“Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, дүрэм журмын хүрээнд байгууллагын үйл ажиллагааг явуулахад хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн актыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангах, сурталчлах, нийт ажилтнуудад хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх

Албан тушаалын зорилт:

- Байгууллагын үйл ажиллагааг МУ-д мөрдөгдөж буй хууль тогтоомж дүрэм журамд нийцүүлэн хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, байгууллагаас гарч буй захирамжлалын болон зохион байгуулалтын баримт бичгүүдийг холбогдох хууль дүрэм журамд нийцэж буйд мониторинг хийх
- Байгууллагыг төлөөлөн шүүх хууль хяналтын байгууллагад нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох
- Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах-Т Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
--------	------------------------------------	-------------------------------	--

1 дүгээр зорилтын хүрээнд	1. Холбогдох хуулиуд болон бусад эрх зүйн баримт бичгийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор холбогдох дүрэм журам зааврын төслийг холбогдох албадуудтай хамтран боловсруулах, хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх, өөрчлөх, зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэнд хяналт тавьж нийт ажилчдад таниулан сурталчлах, мэдлэг мэдээллээр хангах, мөрдүүлэх зөвлөн туслах	Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Т,Ш
	2. Байгууллагын нийт албадуудын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль дүрэм, журам, норм норматив стандартын хэрэгцээг судлан бүртгэж хуулийн шаардлагыг тодорхойлж нийцлийг хангуулах, хянах	Хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилт хангагдсан байна.	Г,Ш
	3. Байгууллагаас гарч байгаа захирамжлалын болон зохион байгуулалтын баримт бичгүүд, тушаал, шийдвэр, гэрээг хянах, санал оруулах	Холбогдох хууль тогтоомжтой гийцсэн байна.	Г,Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1. Хууль шүүх хяналтын байгууллагад газрыг төлөөлөн холбогдох тайлбар, нотлох баримт, бүрдүүлэн гаргах удирдлагад танилцуулах, тайлагнах	Хууль хүрээнд ажилласан байна.	Г
	2. Товлогдсон болон дуудсан цаг хугацаанд хэрэг маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г,Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1. Өнгөрсөн оны баримт бичгийг байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Архивын заавар стандартад нийцсэн байна.	Г
	2. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын дагуу Үндэсний их баяр наадмаар ажиллах. 3. Шаардлагатай тохиолдолд сэлгэн ажиллах.	Архивын заавар стандартад нийцсэн байна.	Т

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр, болон түүнээс дээш зэрэгтэй
Мэргэжил	Хуульч
Мэргэшил	Төрийн удирдлага болон захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байх
Туршлага	Улсад мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад хуульч мэргэжлийн дагуу албан тушаал эрхэлж байсан туршлагатай байх

Ур чадвар	- Ёс зүйн дүрэм сахилга хариуцлага захирах захирагдах ёсыг баримтлан ажиллах - Байгууллагын болон хувь хүний нууц хадгалах - Ашиг сонирхлын зөрчлөөс ангид - Гадаад хэл болон мэдээллийн технологийн зохих мэдлэгтэй байх - Албан хэрэг хөтлөх баримт бичиг боловсруулах - Бусад
-----------	---

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалтны нэр: Газрын дарга Маркетинг хамтын ажиллагааны албаны дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Байхгүй	Бусад харилцах субъект: 1. Холбогдох дээд байгууллага 2. Харилцагч байгууллага 3. Хувь хүн

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн <i>А.Цэнгэлсайхан</i> А.Цэнгэлсайхан 2023 оны 03 дугаар сарын 31 ний өдөр	“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын Дарга <i>С.Сайнбаяр</i> С.Сайнбаяр (Тамга, тэмдэг: 6520 АТА 2023 5761468) 2023 оны 03 дугаар сарын 31 ны өдөр